*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨГЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО, ЯДУУРАЛ САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ДУХЛАЙБААТАР ОВОГТОЙ ЧИНМАНДАХЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Нийгмийн халамжийн шинэчлэлд тусгасан зорилтот өрхийг чадавхжуулах халамжийн үйлчилгээний загвар тодорхойлох зорилгоор АХБ-ны төслийн дэмжлэгтэйгээр “Төгсөлтийн аргачлалыг хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр”-ийг нийслэлийн 3 дүүрэгт туршин хэрэгжүүлэх зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.** “Төгсөлтийн аргачлалыг хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр”-ийг нийслэлийн 3 дүүрэгт туршин хэрэгжүүлнэ. | Гүйцэтгэлийн хувь | 2022 он | Хэрэгжилт-ийг эрчимжүүлнэ. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийг Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй буй “Цар тахлын үе хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2“-ын хүрээнд 2022 оны 7 дугаар сараас 2025 оны 8 дугаар сарыг дуустал буюу 36 сарын хугацаатайгаар хэрэгжүүлж байна. Уг туршилтын хөтөлбөрийг нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний эрхийн бичгийн хөтөлбөрт хамрагддаг 1,259 зорилтот өрхийн нийгмийн болон санхүүгийн чадавх, оролцоог сайжруулах цогц арга хэмжээнд хамруулан 80-аас багагүй хувийг нь бие даан тогтмол орлоготой болж, тогтвортой | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | амьжиргаанд хүргэхийг зорьж байна.<br>Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийн хүрээнд 11 төрлийн тоног төхөөрөмжийг олгож 1256 өрхөд олгосон, өрхүүдийн хөрөнгө ашиглалтын байдалд үнэлгээ хийг ХНХЯ-ны ТНБД-ын ахалсан ажлын хэсгийг шинэчлэн батлуулж, 3 удаагийн хурлыг зохион байгуулсан. Төсөлд хамрагдаж байгаа өрхүүдийг дэмжих, ажлын байраар хангах, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг зах зээлтэй холбох зэрэг ажлуудыг үе шаттай зохион байгуулан ажиллан байна.<br>Хөтөлбөрт хамрагдаж байгаа 1259 өрхийг улирал бүр үндсэн 10 шалгуур үзүүлэлтээр өрх тус бүрээр үнэлдэг. 2024 оны 1 дүгээр улирлаар нийт өрхийн ахиц 63.1 хувьтай байсан бол 2024 оны 4 дүгээр улирлаар нийт өрхийн ахиц 78.1 хувьтай болж 15 хувиар нэмэгдсэн байна. | | |
| | **Дэд арга хэмжээ – 1.1.1:** Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөрийг зөвлөх үйлчилгээгээр үзүүлж буй МУЗН-тай хамтран ажиллана. | Гүйцэтгэлийн хувь | 2022 он | Гэрээнд өөрчлөлт оруулж хамтран ажиллана. | Азийн хөгжлийн банкны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ын дэмжлэгтэйгээр олон улсад амжилттай хэрэгжиж байгаа Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийг нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдэд 2022 оны 06 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн гүйцэтгэгчээр нь Монголын улаан загалмай нийгэмлэг хамтран ажилдаг.<br>“Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2” төслийн гэрээг 1 жилээр сунгасантай холбоотойгоор “Төгсөлтийн аргачлалын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | туршилтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх С010 дугаартай Монголын улаан загалмай нийгэмлэгийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр шинэчлэн байгуулж батлан ажиллаж ажиллаж байна. | | |
| | **Дэд арга хэмжээ – 1.1.2:** Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдэд ур чадвар эзэмшүүлэх сургалт явуулж буй сургалтын байгууллагатай хамтран ажиллана. | Гүйцэтгэлийн хувь | 2023 он | Сургалт зохион байгуулж хамтран ажиллана | Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдэд "Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж төсөлд хамрагдсан өрхүүдийг чадавхжуулах, зорилгоор "Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо", "Ховор Угалз Сургалтын төв", "Тохиниож бизнес инкубатор төв", "Хүүхэд элгэмсэг ирээдүй ТББ" зэрэг сургалтын байгууллагуудтай хамтран ажилласан.<br>Дээрх сургалтын байгууллагуудын мэргэшсэн баш нараар "Оёдлын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн техникийн сургалт" Үсчин, Гоо сайхан, Маникюрын сургалт, "Хоол, хүнс үйлдвэрлэлийн техникийн сургалт", "Гутал үйлдвэрлэлийн техникийн сургалт", "Арьс, эсгий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн техникийн сургалт", "Бизнес удирдахуй" хөрөнгө ашиглахтай холбоотой сургалт, "Дундын хуримтлалын бүлгийн арга зүй" сэдвийн хүрээнд нийт 1865 өрхийг хамруулсан. | | |
| | **Дэд арга хэмжээ – 1.1.3:** ЧД, СХД, БЗД-ийн ЗДТГ-тай хамтран ажиллана. | Гүйцэтгэлийн хувь | 2023 он | Уулзалт зохион байгуулж хамтран ажиллана | "Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн Засаг даргын орлогч дарга болон Тамгын газартай хамтран ажиллаж шаардлагатай хурал уулзалтыг зохион байгуулалтыг хийж ажилласан. Мөн 2024 оны УИХ-ын сонгуультай холбоотой хөтөлбөр хэрэгжиж буй дүүргийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удирдлагууд өөрчлөгдсөн. Иймд ГБХНХЯ-ын Төрийн нарийн бичгийн даргын 2024.11.22-ны өдрийн 03/1229 тоот албан бичгээр Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн Засаг дарга нарт уулзалт зохион байгуулах тухай албан бичгийг хүргүүлж, энэ хүрээнд 12 дугаар сарын 3-нд Чингэлтэй дүүрэгт, 12 дугаар сарын 4-нд Сонгинохайрхан дүүрэгт, 12 дугаар сарын 6-нд Баянзүрх дүүрэгт дүүргийн Засаг даргын орлогч дарга болон нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга нарт холбогдох мэдээллийг тус яам, АХБ-ны төслийн нэгж, Монголын улаан загалмай нийгэмлэгийн зөвлөх багийн төлөөлөл хамтран шаардлагатай мэдээллийг өгч ажилласан. | | |
| | **Дэд арга хэмжээ – 1.1.4:** Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн хөрөнгө ашиглалтыг сайжруулах хүрээнд хяналт тавьж ажиллана. | Гүйцэтгэлийн хувь | 2023 он | Хөрөнгө ашиглалтыг сайжруулж ажиллана | “Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр”-т хамрагдаж буй өрхүүдийг улирал бүр судалгаа авч үнэлдэг.<br>2024 оны 2 улирлын байдлаар нийт өрхийн 79.6 өрх нь хөрөнгөө ашиглаж байсан бол 3 улирлын байдлаар Хөтөлбөрт хамрагдаж нийт өрхийн 82.8 хувь буюу 1036 өрх нь тогтмол ашигладаг болж 0.3 пунктээр өссөн байна.<br>Харин нийт 17.2 хувь буюу 215 өрх нь одоогийн байдлаар хөрөнгөө ашиглаж эхлээгүй байна. Эдгээр өрхийн хөрөнгө ашиглалтыг сайжруулах хүрээнд ажлын байр болон холбон зуучлах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. | | |
| **Зорилт 2. Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах хүрээнд эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлэх зорилтын хүрээнд** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Арга хэмжээ 2.1.** Нийгмийн халамжийн салбарын бодлогод үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргах | Гүйцэтгэлийн хувь | - | Ажлын хэсэгт ажиллана | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/01 тушаалаар Нийгмийн хамгааллын салбарын бодлогод үнэлэлт, дүгнэлт өгөх зөвлөмж гарах ажлын хэсэг байгуулагдсан.<br><br>Уг ажлын хэсэгт яам болон Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Улсын багшийн Их Сургууль зэрэг нийгмийн ажилтан бэлтгэдэг их сургуулиудын төлөөлөл эрдэмтэн багш нар, Австрали, Япон, Америк зэрэг улсад магистр, докторын зэрэг хамгаалсан судлаач нар ажиллаж<br><br>Тус ажлын хэсгийн гишүүд Нийгмийн халамжийн өнөөгийн байдал, тулгамдсан байдал, шинэчлэлийн зорилт, бодлогын зөвлөмжийг ГБХНХ-сайдад 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр танилцуулж ажилласан. | | |
| 2. | **Арга хэмжээ 2.1.1.** "Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх журмын төсөл боловсруулах" ажлын хэсэгт ажиллах | Гүйцэтгэлийн хувь | - | | УИХ-аас Ахмад настны тухай хуульд 2024 оны 06 дугар сарын 05-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж батлагдсантай холбоотойгоор уг хуулийг хэрэгжүүлэх хэд хэдэн журмыг баталж хэрэгжүүлнэ.<br>"Ахмад настанд цогц үнэлгээ хийх" үйлчилгээ үзүүлэх журмын төслийн 6 дугаар зүйл болох "Асаргааны хувилбарт үйлчилгээ" хэсгийг боловсруулан санал өгч ажилласан. | | |
| 3. | **Дэд арга хэмжээ – 2.1.3:** Хүнсний эрхийн бичгийн бичгийн үйлчилгээ үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажиллах | Гүйцэтгэлийн хувь | 2021 он | Ажлын хэсэгт ажиллах | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгох хүнсний эрхийн бичиг олгох журмын төсөл боловсруулан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/79 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна.<br>Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлалыг хамгийн сүүлд Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16, А/04 хамтарсан тушаалаар батлуулсан. Уг аргачлалын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь зорилтот 32.0 мянган өрхийг орлогыг орлуулан тооцох судалгаанд хамруулсан бөгөөд судалгааны ажлыг 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдөр дуусгана.<br>Судалгааны ажлыг дууссаны дараа Захиргааны мэдээлэлд үндэслэсэн босго шугамд харгалзах оноо болон Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг тодорхойлох оноог ажлын хэсэг хуралдаж, холбогдох тооцооллыг хийж ажиллана | | |
| **Зорилт 3.Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 3.1.** Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангаж зөвлөх багтай хамтран ажиллана | Гүйцэтгэлийн хувь | 2023 он | Зөвлөх багтай хамтран ажиллана | Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссаны Монголын улаан загалмай нийгэмлэгийн зөвлөх багийн ажлын 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг төслийн захирлаар 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор батлуулан, хүргүүлэн ажиллана. | | |
| 2 | **Дэд арга хэмжээ 3.1.1.** Төгсөлтийн аргачлалын хөтөлбөрийг эрчимжүүлэх хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/12 тоот тушаалыг шинэчлэн | Гүйцэтгэлийн хувь | 2023 он | | өгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/133 тоот тушаалаар яамны түвшинд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах, дүүргийн түвшинд хэрэгжилтийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулах | | | | эрчимжүүлэх ажлын хэсгийг байгуулан хэрэгжүүлж байна. Улсын Их Хурлын 2024 оны сонгуультай холбоотой Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, болон яамны холбогдох удирдлагууд өөрчлөгдсөн. Иймд төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийг хэрэгжилтийг сайжруулж, эрчимжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/12 тушаалыг шинэчлэн боловсруулан ажиллаж байна. | | |
| 3 | **Дэд арга хэмжээ 3.1.2.** Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2 төслийн нэгжийн хүрээнд нийгмийн халамжийн чиглэлээр ажиллах зөвлөх, төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийг олон нийтэд таниулан сурталчлах, нутагшуулах чиглэлээр хамтран ажиллах байгууллагын ажлын даалгаврыг боловсруулан ажиллах | Гүйцэтгэлийн хувь | - | Ажлын даалгаврыг боловсруулан төслийн нэгжид хүргүүлэн хамтран ажиллана | "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2" төслийн худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, төсөвт өртгийн талаарх мэдээллийг Гэр бүл , хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 03/822 тоот албан бичгээр төслийн нэгжид хүргүүлэн ажилласан.<br><br>Мөн дээрх төслийн хэрэгжих хугацааг 1 жилээр сунгасантай холбоотойгоор төслийн худалдан авах ажлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулахаар Азийн хөгжлийн банкны төв болон баруун, зүүн өмнөд азийн бүсийн хүний болон нийгмийн хөгжлийн захирал хадагтай София Шакилд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 03/1186 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уг санал Азийн хөгжлийн банкны төв салбар дээр хянагдаж байгаа болно. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4. Нийгмийн халамжийг үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хүрээнд олон улсын байгууллага, донор байгууллагуудтай хамтран ажиллах зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 4.1.** Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, бодлогын хүрээнд олон улсын байгууллагатай хамтран ажиллах | Гүйцэтгэлийн хувь | - | Хариуцсан ажлын чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах | Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын хүрээнд хэрэгжиж буй олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцож ажиллаж байна. Тухайлбал: Жайка-гаас хэрэгжүүлж буй зорилтот бүлгийн зорилтот бүлгийн иргэдэд хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгийг үзүүлэх ажлыг загвар төслийн сургалт үйл ажиллагаанд оролцож санал зөвлөмж өгч ажилласан.<br>Мөн Дэлхийн банкнаас зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлт нь улсын хөгжил, эдийн засагт хэрхэн нөлөөлөх” сэдэвт сургалтад хамрагдаж нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийг хэрхэн урьдчилан сэргийлэх талаар санал зөвлөмжтэй танилцаж санал өгч ажиллаа. | | |
| 2. | **Дэд арга хэмжээ 4.1.1** “Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцүүлэг” зохион байгуулна. | Гүйцэтгэлийн хувь | - | | Нийгмийн хамгааллын олон улсын хурлыг 2024 оны 10 дугаар сарын 29,30-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж ажилласан.<br>Уг хуралд Азийн хөгжлийн банкны гишүүн орнууд болох Азербайжан, Пакистан, Филиппин, Индонез, Узбекистан зэрэг улсын төлөөллүүд оролцож, харилцан хоорондоо туршлага солилцож ажилласан.<br><br>Мөн Монгол Улсад үр дүнтэй хэрэгжиж буй "Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ"-ний хэрэгжилт, "Төгсөлтийн аргачлалын хөтөлбөр"-т хамрагдсан өрхүүдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнтэй танилцаж, БЗД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй танилцуулж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийгмийн халамжийн үйлчилгээ болон дээрх хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл өгч ажилласан. | | |
| 3. | **Дэд арга хэмжээ 4.1.2**.“Төгсөлтийн аргачлал”-ын туршилтын хөтөлбөрийн хүрээнд олон улсын туршлага судлах | Гүйцэтгэлийн хувь | - | | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/20 дугаар тушаалын дагуу Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундралаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Филиппин Улсын нийгмийн халамжийн тогтолцоо түүний дотор “Төгсөлтийн аргачлал” туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийг судлах, Монгол Улсад хэрэгжүүлж буй хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний хэрэгжүүлсэн туршлагыг танилцуулж ажиллахаар Филиппин Улсад 2024 оны 02 дугаар сарын 13–17 өдрийн хооронд ажилласан.<br><br>Филиппин Улсын нийгмийн халамжийн тогтолцоо, үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлын хүрээнд Филиппин Улсын Нийгмийн халамжийн яам болон Илоило хотын дарга, захиргааны мэргэжилтнүүдтэй уулзаж, “төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөр”-ийн хэрэгжилт, сайн туршлагын талаар мэдээлэл авч, санал бодлоо солилцож ажиллаа. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг | Төрөлжсөн Цахимжуул | | Сонгогдсон | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн даргын 2024 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цахимжуулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, шаардлагатай мэдээллийг нэгтгэж ажиллах | сан эсэх | - | байгууллагатай хамтран ажиллах | оны А/15 дугаар тушаалын "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний (ахмад настан) цахим систем хөгжүүлэх" ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулан ажилласан. Уг ажлын хэсэгт нарийн бичгээр ажиллаж, ажлын хэсгийн гишүүдийн саналын нэгтгэж энэхүү хөгжүүлэлтийг хариуцан ажиллаж байгаа "Quantum partners" ахлах менежер О.Сарангуайд цахим хаягаар хүргүүлэн ажилласан.<br>Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг цахимжуулах ажлыг зөвлөх үйлчилгээний гэрээгээр үзүүлж гүйцэтгэж буй "Quantum partners" ХХК, ХНХЯ-ны ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ХХҮЕГ болон оролцогч талуудыг оруулсан уулзалт хэлэлцүүлгийг 2024 оны 1.2 дугаар улиралд тухай бүр хуралдаж, холбогдох саналуудын өгч ажилласан. | | |
| 2. | **Арга хэмжээ 1.2.**<br>Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг тодорхойлох босго оноог шинэчлэх | Босго шугамыг шинэчилсэн эсэх | - | Босго шугам шинэчлэн мэдээллийг бэлтгэж ажиллах | Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлалыг хамгийн сүүлд Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16, А/04 хамтарсан тушаалаар батлуулсан.<br>Энэхүү аргачлалын дагуу ҮСХ, УБЕГ, НДЕГ, ХХҮЕГ, ТЕГ, АТҮТ, ГЗБЗЗГ, ТАЗ зэрэг байгууллагуудтай мэдээлэл солилцож цахим мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.<br>2020 онд Монгол Улсын ядуурлын түвшин 27.8 байсан бол 2022 онд Монгол Улсын ядуурлын түвшин 27.1 хувьтай болж өөрчлөгдсөн тул түүнд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | харгалзах оноо буюу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэнийг тодорхойлох босго шугамыг амьжиргааны түвшний үнэлгээний 401.2 оноо болон түүнээс оноогоор тогтоох ажлын мэдээллийг бэлтгэж ажилласан. | | |
| 3. | Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын эрх зүйн орчны шинэчлэлийг танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах | Уулзалт зохион байгуулсан эсэх | - | Хэлэлцүүлгийг зохион байгуулж ажиллах | Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, баримтлах бодлого, эрх зүйн орчны шинэчлэлийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын эрх зүйн орчны шинэчлэлийг танилцуулах" сэдэвт хэлэлцүүлэгтэй холбоотой төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/65 тоот тушаалыг боловсруулан зохион байгуулалтын ажлыг хариуцан ажилласан. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан | Биелэлтийн |

| | | | түвшин | түвшин | | хугацаа | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.1.**<br>Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана. | Суралцсан цаг | - | Сургалтад хамрагдсан байна | Удирдлагын Академиас зохион байгуулсан “Шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих аргачлал боловсруулах нь” сэдэвт сургалтад 2024 оны 10 дугаар сарын 07, 08, 09, 17 өдрүүдэд хамрагдан суралцаж өөрийн мэдлэгээ дээшлүүллээ. | 7-12 | |
| 2 | **Арга хэмжээ 1.2.**<br>Англи хэлний сургалтад хамрагдана. | Суралцсан цаг | - | Сургалтад хамрагдсан байна. | Англи хэлний мэдлэгээ хувиараа цахим сургалтад хамрагдаж, хэлний мэдлэгээ дээшлүүлэн ажиллаж байна.<br>Мөн салбарын мэргэжлийн нэр томьёог судалж албан хэрэгцээндээ ашиглаж байна. | 1-12 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Нэгдсэн Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч
*( Албан тушаал )*

............................ / Д.Чинмандах/
*( Нэр, гарын үсэг )*

2024. 12. 09
*( Огноо )*